

**“ДИСПЕТЧЕРИЙН ҮНДСЭНИЙ ТӨВ” ХХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС**

2017 оны 9 дугаар сарын 11 өдөр

№.07

Улаанбаатар хот

“Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн хурлын тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Компанийн 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, тэнцлийн дүнгийн тухай

ТЭМДЭГЛЭСЭН НЬ:

2017 оны эхний хагас жилд 2,515.4 сая төгрөгийн орлого олж, 2,489.9 сая төгрөгийн зардал гарган, 25.5 сая төгрөгийн ашигтай ажилласан.

Оны эхнээс дансны авлага 39.6 сая төгрөгөөр, урьдчилж гарсан зардал 163.6 сая төгрөг, богино хугацаат зээлийн өр төлбөр 150.8 сая төгрөгөөр өсч, дансны өглөг 955.0 сая төгрөгөөр, урт хугацаат зээлийн өр төлбөр 301,5 сая төгрөг, урдчилж орсон орлого 373,0 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Мөн эхний хагас жилд шатахуун 0,3 сая төгрөг, сэлбэг хэрэгсэл 4,0 сая төгрөг, хангамжийн материал 5,6 сая төгрөг, үндсэн ба нэмэгдэл цалин 8,7 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 4.6 сая төгрөгөөр, албан томилолтын зардал 26,8 сая төгрөг, зохицуулалтын үйлчилгээ 9,9 сая төгрөг, ашиглалтын зардал 7,9 сая төгрөг, үйл ажиллагааны бусад зардал 12,3 төгрөгөөр тус тус хэтэрсэн... гэж тэмдэглэв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:


Гүйцэтгэх захирал Д.Балдоржид даалгах нь:

а. Эхний хагас жилийн тайлан тэнцлээр төлөвлөгөөнөөс хэтэрсэн үндсэн ба нэмэгдэл цалингийн зардал, харилцаа холбооны зардал болон ашиглалтын зардлыг сүүлийн хагас жилд батлагдсан төлөвлөгөөнд барьж ажиллах,

б. Төлөвлөгдөөгүй зардал огт гаргахгүй байх, тэвчиж болох зардлыг хэмнэж ажиллахыг онцгой анхаарах,

в. Үндэсний Аудитын Ерөнхий Газраас компанийн 2016 оны үйл ажиллагаанд хязгаарлалттай дүгнэлт өгснийг хатуу анхаарч, акт, албан шаардлага, зөвлөмжийг заасан хугацаанд нь залруулан, алдааг дахин давтахгүй байх.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ЧИМЭДДОРЖ